



ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмаар Үндэсний батлан хамгаалахын их сургууль /цаашид ҮБХИС гэх/-ийн 2025-2026 оны хичээлийн жилийн бакалаврын болон мэргэжлийн боловсролын элсэлтийг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Монгол Улсын Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/143 дугаар нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", Боловсролын сайдын 2024 оны А/228 дугаар "Босго оноо тогтоох тухай" тушаал, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн захирлын 2020 оны А/133 дүгээр тушаалаар батлагдсан "Дээд боловсролын бакалаврын зэрэг олгох сургалтын журам"-ыг удирдлага болгон элсэлтийг зохион байгуулна.

1.3. ҮБХИС-ийн бакалаврын болон мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг "бүртгүүлэгч", зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийг зохион байгуулахаар томилогдсон комиссыг "төв комисс", бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн комиссыг "салбар комисс", элсэлтийн үйл ажиллагаанд оролцох ажилтныг "комиссын гишүүн" гэнэ.

1.4. Энэхүү журмыг ҮБХИС-ийн <http://mndu.gov.mn> цахим хаяг Facebook-ийн ҮБХИС-ийн дэргэдэх "Эрдэм студи" хуудас болон хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд байршуулан, бүртгүүлэхийг хүсэгчдэд танилцах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.5. Журмын хэрэгжилтэд төрийн захиргааны төв болон бусад байгууллага, олон нийт, эцэг, эхийн төлөөлөл, ҮБХИС-ийн удирдлагын зүгээс хөндлөнгийн хяналт тавих нөхцөлийг бүрдүүлсэн байна.

1.6. Бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрт аймаг орон нутгаас элсэхийг хүсэгчид тухайн аймгийн Засаг даргын тамгын газрын цэргийн штабт, Улаанбаатар хотоос элсэхийг хүсэгчид ҮБХИС-д Боловсролын яамнаас тогтоосон өдрөөс эхлэн ажлын 10 өдөрт багтаан **өөрийн биеэр** ирж бүртгүүлнэ.

1.7. ҮБХИС-ийн бакалаврын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь Цэргийн нэгдсэн дээд сургууль, мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь Цэргийн хөгжмийн политехник коллеж, Ахлагчийн политехник коллеж байна.

1.8. Бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрт элсүүлэх хяналтын тоог захиалагч байгууллага тогтооно.

1.9. Бакалаврын хөтөлбөр:

Цэргийн нэгдсэн дээд сургууль /Цэрэг, батлан хамгаалахын чиглэлээр/:

Зэвсэгт хүчин, төрийн цэргийн байгууллагын офицерын албанд ажиллах хүсэл, эрмэлзэлтэй, бие хүний төлөвшил, бие бялдар, эрүүл мэндийн шаардлага хангасан иргэнийг захиалагч байгууллагуудын мэргэжил, хяналтын тоо, захиалгын дагуу элсүүлэн үнэ төлбөргүй суралцуулж, цэргийн ухааны бакалаврын зэрэг, дэслэгч цол олгоно. Үүнд:

1. Ерөнхий цэргийн команд;
2. Хуягт танкийн команд;
3. Артиллерийн команд;
4. Хуягт танкийн техникийн ашиглалтын инженер;
5. Цэргийн автотехникийн ашиглалтын инженер;
6. Цэргийн холбооны инженер;
7. Цацраг, хими, биологийн хамгаалалт хангалт;
8. Цэргийн инженер;
9. Зенитийн артиллерийн команд;
10. Зенитийн пуужингийн ашиглалтын инженер;
11. Радиотехникийн команд;
12. Кибер аюулгүй байдал;
13. Программ хангамж;
14. Сүлжээний инженер;
15. Цэргийн материал хангалтын мэргэжилтэн.

Бакалаврын хөтөлбөрт суралцагч нь 1, 2, 3 дугаар ангид суралцах хугацаандаа 3.2 буюу түүнээс дээш голчтой суралцсан тохиолдолд **ОХУ, БНХАУ, ХБНГУ, ТУРК УЛС, БНЭУ, ЯПОН УЛС, БНСУ** зэрэг улсуудын цэргийн сургуулиудын сонгон шалгаруулалтад оролцож тэнцсэн тохиолдолд үнэ төлбөргүй суралцах боломжтой.

1.10. Мэргэжлийн боловсролын хөтөлбөр:

а. Цэргийн хөгжмийн политехник коллеж нь мэргэжлийн боловсролын хөтөлбөрт Ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр анги төгссөн хөгжмийн авьяастай сурагчдыг элсүүлэн, үлээвэр, цохивор найрал хөгжмийн сурагчаар үнэ төлбөргүй 2,5 жил суралцуулж “Мэргэжлийн боловсролын үнэмлэх”, үргэлжлүүлэн 1,5 жил суралцуулж “Техникийн боловсролын диплом” олгож, дэд ахлагч цолтой төгсгөнө.

б. Ахлагчийн политехник коллеж нь цэргийн зэвсэглэл, техник, тусгай тоноглол, төхөөрөмжийн чиглэлээр мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт **22** хүртэлх насны иргэнийг элсүүлэн 1 жилийн хугацаанд үнэ төлбөргүй суралцуулж, цэргийн мэргэжил эзэмшүүлэн Зэвсэгт хүчний ахлагчийн албанд шилжүүлнэ. Үүнд:

1. Явган цэргийн байлдааны машины механик жолооч;
2. Явган цэргийн байлдааны машины наводчик оператор;
3. Танкийн механик жолооч;
4. Зенит өөрөө явагч суурийн техникч оператор;
5. Артиллерийн бууны наводчик;

6. Артиллерийн тагнуулчин-гал засварлагч;
7. Зэвсгийн засварчин-нярав;
8. Автотехникийн цахилгаанчин;
9. Автотехникийн засварчин-нярав;
10. Радиолокацын станцын оператор-планшетчин;
11. Инженерийн дугуйт машины механик жолооч;
12. Химийн зааварлагч;
13. Цахилгаан холбоо, компьютер сүлжээний техникч;
14. Радиотелеграфчин.
15. Хуягт тээвэрлэгчийн механик жолооч;

Хоёр. Элсэгчдэд тавигдах шаардлага

2.1. Элсэхээр бүртгүүлэгч нь өөрийн хүсэл сонирхол, итгэл үнэмшлээрээ сонголтоо хийсэн, бие бялдар, "Элсэлтийн ерөнхий шалгалт" ЭЕШ-ын босго онооны шаардлагыг хангасан, ёс суртахууны зөв төлөвшилтэй, суурь өвчингүй, бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой Монгол Улсын иргэн байна.

2.2. Бүртгүүлэгч нь цэргийн мэргэжлийн бакалаврын хөтөлбөрт **17-22** насны, мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт ЭЕШ өгсөн **22** хүртэлх насны эрэгтэй **170** см, эмэгтэй **165** см-ээс дээш өндөртэй, биеийн жингийн зохистой харьцааг хангасан, байвал зохино.

2.3. Бакалаврын хөтөлбөрт суралцах хүсэлтэй дараах бүртгүүлэгчдэд элсэлтийн ерөнхий шалгалтын оноо шаардахгүй. Үүнд:

а. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон улсын төрөлжсөн олимпиадын эхний 5 байрт шалгарсан иргэн;

б. Гадаад болон дотоодын ерөнхий боловсролын сургуульд суралцаж бүрэн дунд боловсрол эзэмшин, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын дүн, оноог Боловсролын үнэлгээний төвөөр дүйцүүлэн тооцуулж, батламж авсан иргэн.

2.4. Эрүүгийн хариуцлага хүлээж байсан болон хүлээж байгаа иргэнийг тус сургуулийн бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрт бүртгэхгүй.

2.5. Бүртгүүлэгч ҮБХИС-д бүртгүүлэхээс өмнө элсэлтийн ЭЕШ-ын шалгуулагчийн буланд нэвтэрч, өөрийн хувийн мэдээлэл болон дүнтэй танилцаж, зөрчилтэй асуудал байвал урьдчилан шийдвэрлүүлсэн байна.

2.6. Бүртгүүлэгч энэ журмын 6-д заасан зардлыг хариуцан, төлөхийг хүлээн зөвшөөрсөн байна.

2.7. Бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрт бүртгүүлэгч нь 2024, 2025 оны монгол хэл, бичгийн босго оноо хангасан, тухайн хөтөлбөрт орох элсэлтийн шалгалтын нэгдүгээр хичээлүүдээс 1 хичээлийн босго оноог заавал хангасан, эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн тохиолдолд энэ журмын хүснэгт 4-т заасан ур чадварын шалгалт өгнө. (Ур чадварын шалгалтын үнэлгээг Элсэлтийн ерөнхий шалгалтын 2 дахь хичээлийн дүнд тооцно).

2.8. Цэргийн нэгдсэн дээд сургуулийн бакалаврын хөтөлбөр:

Хүснэгт 1

№	Хөтөлбөрийн нэр	Элсэлтийн шалгалтын хичээл, босго оноо			
		I-хичээл		II-хичээл	
1	Ерөнхий цэргийн команд	Математик, Нийгэм судлал	490	Ур чадвар	490
2	Артиллерийн команд				
3	Хуягт танкийн команд				
4	Хуягт танкийн техникийн ашиглалтын инженер				
5	Цэргийн холбооны инженер				
6	Цэргийн инженер				
7	Цэргийн автотехникийн ашиглалтын инженер				
8	Цацраг, хими, биологийн хамгаалалт, хангалт				
9	Зенитийн артиллерийн команд				
10	Зенитийн пуужингийн ашиглалтын инженер	Физик, Математик	490		
11	Радиотехникийн команд				
12	Кибер аюулгүй байдал	Математик, Физик	550		
13	Программ хангамж				
14	Сүлжээний инженер				
15	Цэргийн материал хангалтын мэргэжилтэн	Математик	490		

2.9.1. Цэргийн хөгжмийн политехник коллежийн мэргэжлийн боловсролын хөтөлбөр:

Хүснэгт 2

I-хичээл	II-хичээл	Нэмэлт шалгуур	Босго оноо
Математик	Монгол хэл	Эрүүл мэндийн үзлэг, ур чадварын шалгалт	Шалгалтыг 100% гэж тооцон 70%-иас дээш амжилт үзүүлбэл тэнцэх шалгуурыг хангасан

2.9.2. Ахлагчийн политехник коллежийн мэргэжлийн боловсролын хөтөлбөр:

Хүснэгт 3

I-хичээл	II-хичээл	Нэмэлт шалгуур	Босго оноо
Математик, физик, хими, нийгэм судлал, гадаад хэл (аль нэг хичээлээр ЭЕШ өгсөн байна.)	Ур чадвар	Эрүүл мэндийн үзлэг	Ур чадварын шалгалтын босго оноо 490

УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ, НОРМАТИВ

хүснэгт 4

№	Бие бялдрын шалгуур	Дасгалын төрөл	Аргачлал	тэнцүүлэх үзүүлэлт	Гүйцэтгэлийн үнэлгээ	Тэнцүүлэх босго оноо
1	Хүч	хэвлийн таталт (эрэгтэй)	Тоо	40-с дээш	100%=800 оноо	490
		хэвлийн таталт (эмэгтэй)		40-с дээш		
2	Тэсвэр	1000 метр гүйлт (эрэгтэй)	мин	4.20 ^l -с дээш		
		1000 метр гүйлт (эмэгтэй)		6.20 ^l -с дээш		
3	Хурд	100 метр гүйлт (эрэгтэй)	сек	15.00 ^l -с дээш		
		100 метр гүйлт (эмэгтэй)		18.00 ^l -с дээш		

Тайлбар: Дээрх үзүүлэлтийн 2 ба түүнээс дээш дасгалыг биелүүлсэн тохиолдолд тэнцэнэ. 100 метр, 1000 метрийн гүйлтийн аль нэг дасгалд заавал тэнцсэн байвал зохино.

4.5.Хөтөлбөр бүрээр онооны дарааллаар байр эзлүүлж, хяналтын тоонд багтсан элсэгчдийг ЭЕШ-ын бүртгэлийн дугаараар мэдээллийн самбар, сургуулийн цахим хуудсанд байршуулна.

4.6.Цэргийн нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэгээр тэнцээгүй, бие бялдрын шалгуур үзүүлэлтийг хангаагүй элсэгчдийг жагсаалтаас хасаж, онооны дарааллаар дараагийн бүртгүүлэгчид сонголтыг шилжүүлнэ.

4.7.Шалгалтын дүнг **07 дугаар сарын 25-ны өдрийн 14.00** цагт нийтэд мэдээлнэ.

Тав. Элсэгчээр бүртгэх

5.1.Цэргийн мэргэжлийн бакалавр, мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт тэнцсэн элсэгчдэд **07 дугаар сарын 28-ны 14.00-17.30** цагт “ҮБХИС-д суралцах эрхийн бичиг” олгоно.

5.2. Заасан хугацаанд ирж, суралцах эрхийн бичгээ аваагүй бүртгүүлэгчийг суралцахаас татгалзсанд тооцож, онооны дарааллаар дараагийн элсэгчид сонголтыг шилжүүлнэ.

5.3. Бүртгүүлэгч нь суралцах эрхийн бичиг авахдаа дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Иргэний үнэмлэх (e-mongolia);
- Боловсрол эзэмшсэнийг гэрчлэх баримт бичиг (Суурь болон бүрэн дунд боловсролын гэрчилгээ);
- Сурагчийн хувийн хэрэг;
- БХЯ, ЗХЖШ-ын зөвшөөрөл, анги байгууллагын тодорхойлолт (зөвхөн алба хаач буй ахлагч нарт хамаарна);
- 3х4 хэмжээний цээж зураг 4 хувь;
- Гурван үеийн намтар (Өөрийн болон эцэг, эхийн дэлгэрэнгүй намтрыг өөрийн гараар бичсэн байна);
- Гэмт хэрэгт холбогдож байгаагүйг нотлох цагдаагийн байгууллагын тодорхойлолт (e-mongolia);

5.4. Элсэгч нь "ҮБХИС-ийн дүрэм"-д заасан суралцагчдад тавигдах шаардлагын дагуу бүрэлдэхүүн сургуулийн захирал, Эрдэм шинжилгээ, сургалтын албатай "Суралцах гэрээ" байгуулна.

5.5. Суралцах эрхийн бичгийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

Зургаа. Элсэлтийн шалгалтын зардал

6.1. Элсэхийг хүсэгч дор дурдсан зардлыг хариуцна.

- Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөр;
- Сургалтын удирдлага, мэдээллийн систем ашиглалтын төлбөр;
- Цэргийн анхан шатны бэлтгэл сургалттай холбоотой зардал;
- Гэнэтийн ослын даатгалын төлбөр (заавал).

Долоо. Өргөдөл, гомдол шийдвэрлэх

7.1. Элсэлттэй холбоотой өргөдөл, гомдлыг 07 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл, цэргийн анхан шатны бэлтгэлт сургалттай хамаарал бүхий өргөдөл, гомдлыг 08 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл тус тус хүлээн авна.

7.2. Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.

7.3. Өргөдөл, гомдлын хариуг биечлэн эсвэл бичгээр мэдэгдэнэ.

Найм. Бусад

8.1. Элсэгч цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд хамрагдаж, цэргийн тангараг өргөнө.

8.2. Элсэгчдэд бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөрүүдээ танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг цэргийн анхан шатны бэлтгэл сургалт явагдах хугацаанд зохион байгуулна.

8.3. ҮБХИС-д суралцах нөхцөлийг хангасан "Бакалаврын зэргийн диплом"-той элсэгчдийг суралцуулах асуудлыг "ҮБХИС-д боловсролын бакалаврын зэрэг олгох сургалтын журам"-ыг үндэслэн хэрэгжүүлнэ.

Харилцах утас, мэйл хаяг:

- ҮБХИС-ийн Сургалтын хэлтэс: 453164, info@mndu.gov.mn
- ҮБХИС-ийн жижүүр: 480908
- Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, Улаанхуаран
www.mndu.gov.mn

СУРГАЛТЫН ХЭЛТЭС